



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
АЛБАН ДААЛГАВАР

2018 оны 05 сарын 20 өдөр

Дугаар № 06

Алтай

Газар тариалангийн ажлыг  
эрчимжүүлэх тухай

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн төмсний хэрэгцээг 100 хувь, хүнсний ногооны хэрэгцээний 60-80 хувь, жимс жимсгэний хэрэгцээний 5-10 хувь, гурилын хэрэгцээний 15-25 хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангах зорилт тавьсан. Эдгээр зорилтыг хангах зорилгоор өнгөрсөн оноос эхлэн "Төмс", "Хүлэмж" хөтөлбөрүүдийг батлан хэрэгжүүлж эхэлснээр гурилын 5.9 хувь, төмсний 30 хувь, хүнсний ногооны 16.8 хувь, жимсгэний 3.2 хувийг тус тус хангаж байгаа юм.

Иймээс хөтөлбөрүүдэд тусгагдсан зорилтуудыг биелүүлэх, газар тариалангийн бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор ДААЛГАХ нь:

Нэг. Сумын Засаг дарга нарт:

1.1. Тариалах талбай, хураан авах ургацыг хавсралтад заасан шалгуурын дагуу биелүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах;

1.2. Хаврын тариалалтад шаардагдах үрийг захилга, гэрээний дагуу тариаланчдад олгож, үрийн дутагдалгүйгээр тариалалтын ажлыг 06 дугаар сарын 10-ны дотор зохион байгуулж, сумынхаа орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөнөөс тодорхой хэмжээний хөрөнгө гаргаж тариалалтын ажилд зарцуулах;

1.3. Тариалалт, ургац хураалтад шаардлагатай шатахуунаар хангах ажлыг шатахуун нийлүүлэгч аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулах замаар шийдвэрлэх;

1.4. Шинээр газар тариалан эрхлэх болон газар тариалангийн үйлдвэрлэлээ өргөжүүлж байгаа тариаланчид, аж ахуйн нэгжийг дэмжих, шинээр газар эзэмшүүлэх арга хэмжээ авах;

1.5. Тариалалт, ургац хураалтад шаардлагатай шинээр авах техник, тоног төхөөрөмжийн захиалгыг Хүнс, хөдөө аж ахуйн газарт 03 дугаар сарын 25-ны дотор өгч, хамтран шийдвэрлэх;

1.6. "Төмс" хөтөлбөрийн хүрээнд сумынхаа төмсний хэрэгцээний 50 хувийг хангахаар зохион байгуулалтын арга хэмжээ авч зоорийн ашиглалтыг нэмэгдүүлэх, шинээр зоорь барих, дараа жилийн тариалалтад шаардагдах үрийг нөөцлүүлэх арга хэмжээ авах;

1.7. "Хүлэмж" хөтөлбөрийн хүрээнд хуучин ашиглаж байсан хүлэмжийн ашиглалтыг сайжруулж, шаардлагатай нийлэг хальсан бүтээлгээр хангах, шинээр 250 м<sup>2</sup>-аас доошгүй дулаалгатай уртасгасан цагаар ажиллах хүлэмж байгуулах, усалгааны тоног төхөөрөмжөөр хангах, таримлын нэр төрлийг олшруулах, арчилгаа тордолтыг сайн хийлгэж, хүнсний ногооны хангамжийг нэмэгдүүлэх;

1.8. Хаврын тариалалтын өмнө тариалан эрхлэгчдийн зөвлөгөөнийг зохион байгуулж зөвлөгөөнөөс гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх;

1.9. Тариаланчдад газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх аж ахуй эрхлэлтийн болон технологийн сургалтыг 3-аас доошгүй удаа зохион байгуулах;

1.10. Сум хөгжүүлэх сангийн зээлийг тариаланчдад эхний ээлжинд олгож, тариаланчдыг жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангийн зээл, бусад гадаад дотоодын зээл, төсөл хөтөлбөрт хамруулах арга хэмжээ авах;

1.11. Орон нутагт тариалсан төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнийг сургуулийн дотуур байр, үдийн цай, цэцэрлэгийн хүүхэд, эмнэлэгт эмчлүүлэгчдийн хоол хүнсэнд авч хэрэглэх талаар албан байгууллагын дарга, эрхлэгч нартай гэрээ байгуулж, биелэлтийг дүгнэж ажиллах;

1.12. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны харьяат Тариалан эрхлэлтийг дэмжих сан болон аймгийн Тариалан эрхлэлтийг дэмжих сангаас авсан техник тоног төхөөрөмж, үр, суулгацын өрийг барагдуулах ажлыг Хүнс, хөдөө аж ахуйн газартай хамтран зохион байгуулах;

1.13. Тариаланчдын борлуулалтын орлогыг нэмэгдүүлэхийн тулд сумдаа үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, аймагт зохион байгуулагдах үзэсгэлэн худалдаанд оролцуулах;

1.14. Томоохон аж ахуйн нэгжүүдийг мэргэжлийн агрономичтой болгох, мал эмнэлэг үржлийн тасгийн ус, бэлчээр тэжээл хариуцсан мэргэжилтэнд агрономич мэргэжлийн хүн авч ажиллуулах;

1.15. Албан даалгаврын хэрэгжилтийн дүн тайлан мэдээг 06 дугаар сарын 15, 11 дүгээр сарын 01-ний дотор ирүүлэх;

Хоёр: Хүнс, хөдөө аж ахуйн газарт:

2.1. Хаврын тариалалтад шаардлагатай төмс, хүнсний ногооны үр, бордоог сумдын захиалгын дагуу нийлүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах;

2.2. Тариалан эрхлэгчдийг үр болон техникийн шинэчлэлт хийхэд нь гадаад, дотоодын хөнгөлөлттэй зээл, тусламжид хамруулах;

2.3. Тариалан эрхлэлтийг дэмжих сантай өмнөх жилүүдэд үүссэн өр авлагыг 50-иас доошгүй хувиар барагдуулах арга хэмжээ авах;

2.4 Тариалалт, ургац хураалтын өмнө тариалангийн бүс нутгуудаар явж газар дээр нь үзэж, тариалсан талбай хураан авах ургацын балансыг тогтоож, дүн мэдээг тухай бүр нь Засаг даргын зөвлөлд танилцуулах;

2.5.Тариалан эрхлэгчдийг нэгдсэн удирдлагаар хангаж мэргэжлийн зөвлөгөө, шинэ мэдээ мэдээллээр хангах, сумдын газар тариалан эрхлэгчдийн зөвлөгөөнд оролцож аймгийн бодлогыг танилцуулах, үзүүлэх сургалт зохион байгуулах;

2.6. Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд газар тариалангийн талаар орсон зорилтуудыг бүрэн хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах;

2.7. “Хүлэмж”, “Төмс” хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ажлыг хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтын заалт бүрээр хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах, үр дүнг тооцох;

2.8. Шинээр байгуулагдсан болон зураг төсөв нь хийгдсэн услалтын системийг эзэнтэй болгож ашиглаж эхлүүлэх, бусад услалтын системийн ашиглалтыг сайжруулж, тариалах талбай хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээ авах;

2.9. Хаврын тариалалтын бэлтгэл ажлын явцын мэдээлэл, цаашид авах арга хэмжээний саналыг 03 дугаар сарын 30-ны дотор Засаг даргын зөвлөлд танилцуулах;

2.10. Албан даалгаврын хэрэгжилт, үр дүнг 07 дугаар сарын 01, 11 дүгээр сарын 10-ны дотор Засаг даргын зөвлөлд танилцуулах;

Гурав: Албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс /С.Байгальмаа-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.ГАНСЭЛЭМ

Аймгийн Засаг даргын 2018 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 02 дугаар албан даалгаврын хавсралт

ДИСА00042

АЛБАН ДААЛГАВРЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

№	Сумын нэр	Тариалсан талбай /га/		Хураан авах нийт ургац /тонн/		Хураан авсан үр тариа /тонн/		Хураан авсан төмс /тонн/		Хураан авсан хүнсний ногоо /тонн/		Тэжээлийн ургамал /тонн/	
		Суурь түвшин 2017	Хүрэх түвшин 2018	Суурь түвшин 2017	Хүрэх түвшин 2018	Суурь түвшин 2017	Хүрэх түвшин 2018	Суурь түвшин 2017	Хүрэх түвшин 2018	Суурь түвшин 2017	Хүрэх түвшин 2018	Суурь түвшин 2017	Хүрэх түвшин 2018
1	Алтай	11.3	15	18.6	32.6	0	0	12.3	25	4.8	5.6	1.5	2
2	Баян-Уул	0.26	2	3.04	3.8	0	0	2.3	3	0.74	0.8	0	0
3	Бигэр	131.8	134	137	199.9	1.4	4	7.5	20	1.5	7	126.6	168.9
4	Булгат	107.8	125	283.9	313	18.5	22	30	40	30.4	31	205	220
5	Дарив	7.3	15	6.98	12	1.1	2	2.5	4	1.98	2	1.4	4
6	Дэлгэр	162	180	24.57	119.6	0	6	6.15	30	13.42	68.6	5	15
7	Жаргалан	14.1	35	38	60	0	2	8	12	20	22	10	24
8	Тайшир	119.6	125	181.3	251.4	34.5	40	56.3	60	0.5	1.4	90	150
9	Тонхил	4.1	7	12.6	31.7	0	0	9	24	3.6	7.7	0	0
10	Төгрөг	21.6	25	58.5	90	5.5	8	18	30	15	16	20	36
11	Халиун	89.9	110	424.5	518	7.7	10	325.5	360	75.3	128	16	20
12	Хөхморьт	0.32	1	3.2	4.5	0	0	0.2	1	3	3.5	0	0
13	Цогт	258	260	559	1020	25	60	60	100	324	350	150	510
14	Цээл	38.8	43	99.2	145.5	0	0	19.5	36	16.9	18.9	62.8	90.6
15	Чандмань	224.6	250	1034.2	1081.2	146	160	52.3	80	9.9	11.2	826	830
16	Шарга	81	90	235	320	50	70	95	150	70	75	20	25
17	Эрдэнэ	0.3	2	38.3	47	0	0	19.5	25	12	14	6.8	8
18	Есөнбулаг	60.4	70	270.4	428.8	20.2	30	118.7	200	69.8	128.8	61.7	70
	Дун	1333.2	1489	3428.29	4679	309.9	414	842.75	1200	672.84	891.5	1602.8	2173.5